



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 340 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсгийн ажиллах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бүртгэлийн хяналтын журам”-ыг 3 дугаар хавсралтаар, “Үйлдвэрийн бүсэд замын хөдөлгөөнд оролцох журам”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам”-ыг 5 дугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заварчилгаа өгөх журам”-ыг 6 дугаар хавсралтаар, “Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дээрх журмуудыг “Таван толгой түлш” ХХК-ийн нийт ажилтан албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага, тэдгээрийн ажилтнууд батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Дээрх журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрхзүй, аудитын алба болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын хэсэгт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР



ХАБЭА-н хяналтын
хэсгийн ажиллах
журам

СҮАЖ- ХХАЖ-005


Хувилбар 1

Тушаал № 1/36



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

	ХАБЭА-н хяналтын журам	СҮАЖ-ХХЖ-006	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2019 он сар өдөр
		Тушаал №	

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../ /...../	Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

ХАБЭА-н хяналтын журам	СҮАЖ-ХХЖ-006
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

ХАБЭА-н хяналтын журам	СҮАЖ-ХХЖ-006
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Зорилго.....	4
Хоёр. Хамрах хүрээ	4
Гурав. Нэр томъёо, товчилсон үгийн тайлбар.....	4
Дөрөв. Журмаар зохицуулах үйл ажиллагаа	4
Тав. Хариуцлага	6

ХАБЭА-н хяналтын журам	СҮАЖ-ХХЖ-006
	Хувилбар: 1

Нэг. Зорилго

1.1. Энэхүү журам нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн бодлогын хэрэгжилтийг хангахын тулд ХАБЭА-тай холбоотой хууль, дүрэм, журам, зааврын мөрдөлт, аюул эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, гүйцэтгэл, ажилтнуудын хүлээсэн үүргийн биелэлт, ажлын байр, орчны аюулгүй байдалд ХАБЭА-н хяналт шалгалт хийх, залруулах, гүйцэтгэлийг хянахтай холбоотой үйл ажиллагаа, харилцааг зохицуулна.

1.2. Журмыг ХАБЭА-н тухай хууль, компанийн ХАБЭА-н бодлого, хууль эрх зүйн бусад актыг үндэслэн боловсруулсан бөгөөд энэхүү журамд заагдаагүй асуудлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журмыг компанийн нийт ажилтнууд дагаж мөрдөнө.

Гурав. Нэр томъёо, товчилсон үгийн тайлбар

3.1. ХАБЭА-н хяналт шалгалт гэж ХАБЭА-тай холбоотой хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааврын хэрэгжилт, технологийн процесс, ажлын байр, орчин, ажилбарын аюул эрсдэлийг илрүүлж, үнэлсэн байдал, арилгах бууруулах ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, зөрчилтэй үйл ажиллагаа, үйлдлийг нэн даруй таслан зогсоож залруулах, зөв хандлага дадлыг хэвшүүлэн, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлж, аюул эрсдэлээс сэргийлэх зорилготой хяналтыг хэлэх ба бүрэлдэхүүн, давтамжаас нь хамааруулж, ХАБЭА-н ээлжит (1,2-р шатны хяналт шалгалт) ба зорилтот үзлэг гэж ангилна.

3.2. ХАБЭА Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

3.3. ХАБ Хөдөлмөрийн аюулгүй байдал

3.4. ИТА Инженер техникийн ажилтнууд

3.5. ГАБ Галын аюулгүй байдал

3.6. ЭАТ Эмнэлгийн анхан шатны тусламж

Дөрөв. Журмаар зохицуулах үйл ажиллагаа

4.1 Хабэа-н ээлжит 1-р шатны хяналт шалгалтыг анхан болон дунд шатны удирдлага (ээлжийн ахлах, ашиглалтын инженер) өдөр (ээлж) бүр, 2-р шатны хяналт шалгалтыг ХАБЭА-н ажилтан, хяналтын инженер нар 14 хоног тутамд нэгээс доошгүй удаа хийнэ.

4.2. Анхан болон дунд шатны удирдлага нь ажилтны санаачлага, давтагдан гардаг зөрчил, өндөр эрсдэлтэй ажлын байр, орчин, ажилбар (машин механизм, тоног төхөөрөмж, түүний систем, зам талбай, багаж хэрэгсэл цахилгаан, дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт, тоосжилт г.м) –ээс тодорхой нэг чиглэлийг сонгон, зорилтот хяналт шалгалт хийнэ.

ХАБЭА-н хяналтын журам	СҮАЖ-ХХЖ-006
	Хувилбар: 1

4.3. Хяналт шалгалт хийсэн албан тушаалтан нь үзлэгийн үр дүнг баримтжуулж, зөрчлийн мэдээллийг ХАБЭА-н хяналтын хэсэгт танилцуулна.

4.4. ХАБЭА-н ээлжит 1-р шатны хяналт шалгалт:

4.4.1. ХАБЭА-тай холбоотой хууль, дүрэм журам, зааврын мөрдөлт

4.4.2. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн ашиглалт

4.4.3. Ажлын байр, орчны тоосжилт, цэвэрлэгээ, эмх цэгц, аюулгүй байдал,

4.4.4. Технологийн горим, паспорт, технологийн картын мөрдөлт,

4.4.5. Машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал,

4.4.6. Хаалт, хашилт, хамгаалалт, газардуулгын бүрэн бүтэн байдал битүүмжлэл, цэвэрлэгээ, эмх цэгц, галын аюулгүй байдал,

4.4.7. Тэмдэг тэмдэглэгээ, санамж, зурагт хуудас, ХАБЭА-н самбарын мэдээллийн шинэчлэлт

4.4.8. Өндрийн халуун хэмийн, хязгаарлагдмал орон зайн аюулгүй ажиллагаа

4.4.9. Өргөх шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа, оосорлох хэрэгслийн аюулгүй байдал,

4.4.10. Галын аюулгүй байдал, гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдэл, ашиглалт, үзлэг, цэвэрлэгээ үйлчилгээ.

4.4.11. Ажлыг аюулгүй гүйцэтгэх зөв хандлага, дадлыг хянаж, зөрчилтэй үйл ажиллагаа, үйлдлийг нь нэн даруй зогсоож залруулна.

4.5. ХАБЭА-н ээлжит 2-р шатны хяналт шалгалт:

4.5.1. ХАБЭА-н ээлжит 1-р шатны үзлэгийн заалт,

4.5.2. 1-р шатны үзлэгийн чанар, баримтжуулалт

4.5.3. ХАБЭА-н сургалт зааварчилгаа

4.5.4. Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан төлөвлөгөөний гүйцэтгэл

4.5.5. Аюулын илрүүлэлт, мэдээлэлт, арилгалт, Аюулгүй ажиллагааны хурлын чанар, хамрагдалт;

4.5.6. Онцгой байдал болон гамшгийн төлөвлөгөө, тодотгол

4.5.7. Ажлын байр орчны зохион байгуулалт, стандартын нийцлэл, агааржуулалт, гэрэлтүүлэг, дулаан, цахилгаан хангамжийн хэвийн аюулгүй ажиллагаа

ХАБЭА-н хяналтын журам	СҮАЖ-ХХЖ-006
	Хувилбар: 1

4.5.8. Хамгаалах хэрэгсэл, өргөн тээвэрлэх машин механизм, оосорлолт хэрэгслийн туршилт баталгаажуулалт;

4.6. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг нэн даруй арилгах, залруулах талаар холбогдох албан тушаалтан хариуцах бөгөөд аюул, эрсдэл, зөрчлийг арилгах боломжгүй бол удирдлагадаа мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авахуулна.

4.7. Хяналт шалгалт хийсэн албан тушаалтан нь ажилтны амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц үйл ажиллагаа, үйлдлийг баримтжуулж, зөрчил арилтал түр зогсооно. Энэ тухай холбогдох ажил удирдагчид мэдэгдэн, гүйцэтгэлийг хянана.

Тав. Хариуцлага

5.1. Журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан компанийн дотоод журам, бусад дүрэм журмын дагуу хариуцлага тооцно.